

**ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД  
ОРОХ ИРГЭНИЙ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН  
БОЛОН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ  
АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн дагуу үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд орох иргэний мэдээллийн нэгдсэн сан (цаашид “мэдээллийн сан” гэх)-г бүрдүүлэх, түүний мэдээллийг тогтмол шинэчлэх, мэдээллийн санд бүртгэлтэй иргэд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд томилох, үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, түүний гишүүдийн урамшууллыг зохицуулахад оршино.

1.2. Захиалагч нь хуульд зааснаар үнэлгээний хороо байгуулалгүй зохион байгуулж буй тендер шалгаруулалттай холбоотой урилга нийтлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлэх харилцаанд энэ журмыг дагаж мөрдөнө.

**Хоёр. Мэдээллийн сан бүрдүүлэх,  
түүний мэдээллийг шинэчлэх**

2.1. Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь холбогдох журамд заасны дагуу худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан иргэн (цаашид “худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан” гэх)-ийн мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн санг худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-д байршуулна.

2.2. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан нь гэрчилгээний хүчинтэй хугацаанд хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасанд тооцно.

2.3. Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан нь хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт заасан үүргээ зөрчсөн болох нь тогтоогдсон бол Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ тухай захиалагч болон бусад эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мэдээллийг үндэслэн тухайн мэргэшсэн ажилтны мэдээллийн сангийн мэдээлэлд тэмдэглэл үйлдэнэ. Ийнхүү тэмдэглэл үйлдсэнээс хойш 1 жилийн хугацаанд тухайн мэргэшсэн ажилтныг хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.4 дэх заалтын шаардлагыг хангахгүй болсон гэж үзнэ.

**Гурав. Үнэлгээний хороо байгуулах,  
өөрчлөлт оруулах, татан буулгах**

3.1. Захиалагч хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан тохиолдолд үнэлгээний хороо заавал байгуулна.

3.2. Захиалагчийн шийдвэрээр үнэлгээний хороог шинээр байгуулж, өөрчлөлт оруулан, татан буулгана.

3.3. Захиалагч үнэлгээний хороо татан буулгасан тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн дагуу түүний эрх, үүргийг захиалагч залгамжилна.

3.4. Энэ журмын 3.3 дахь заалт нь үнэлгээний хорооны гишүүд хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

3.5. Үнэлгээний хорооны гишүүд нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 5-аас доошгүй сондгой тооны гишүүдтэй байна.

3.6. Захиалагч үнэлгээний хорооны гишүүдийг томилохдоо тухайн ажилтан болон иргэн нь мэдээллийн санд бүртгэгдсэн бөгөөд үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахтай холбоотойгоор хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгана.

3.7. Үнэлгээний хороо үйл ажиллагаа явуулж байх хугацаанд тухайн үнэлгээний хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон эсхүл үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах эрхгүй болсон бол захиалагч нэн даруй шийдвэр гаргаж түүнийг үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлөх ба шаардлагатай шинэ гишүүнийг нөхөн томилно.

3.8. Орон нутагт хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн дагуу үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах иргэнийг тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас баталсан жагсаалтаас сонгоно.

3.9. Тендер шалгаруулалтад тусгайлан нарийн мэргэжлийн ажилтан /мэргэжилтэн/ шаардлагатай, захиалагчийн боловсон хүчний дотоод нөөцөд тухайн чиглэлээр мэргэшсэн ажилтан /мэргэжилтэн/ байхгүй тохиолдолд захиалагч өөрийн санаачилгаар, эсхүл үнэлгээний хорооны хүсэлтээр мэргэжлийн шинжээч, зөвлөхийг үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд оруулж болно. Мэргэжлийн шинжээч, зөвлөхийг сонгоход Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн түүний харьяалах байгууллагын удирдлагатай зөвшилцөж томилно.

3.10. Хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн дагуу томилогдох гишүүнийг үнэлгээний хорооны дарга, нарийн бичгийн даргаар томилохгүй.

3.11. Үнэлгээний хороонд томилогдсон гишүүд нь хуульд заасан шаардлагыг хангаж байгаа болон хуульд заасан чиг үүргийг шударгаар хэрэгжүүлэх тухай мэдэгдлийг энэ журмын Хавсралт 1-ийн дагуу гаргаж, баталгаажуулна.

3.12. Тендерийн нээлт хийгдсэний дараа үнэлгээний хорооны гишүүн тус бүр хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.1, 47.3.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.4 дэх заалт зөрчигдөөгүй бөгөөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын дагуу гаргаж захиалагчид хүргүүлнэ.

3.13. Үнэлгээний хорооны гишүүн тухайн тендер шалгаруулалтад оролцож буй тендерт оролцогч болон түүнийг шууд болон шууд бусаар төлөөлөх этгээдтэй

ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл ирүүлсэн бол захиалагч дараах арга хэмжээ авна:

3.13.1. Хуулийн 47 дугаар зүйлийн 47.3.2, 47.3.3 дахь заалт зөрчигдсөн бол үнэлгээний хорооны гишүүнээс хасах шийдвэр гаргах;

3.13.2. Бусад ашиг сонирхлын мэдүүлгийн хувьд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэгт зааснаар бичгээр шийдвэр гаргана.

### **Дөрөв. Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, гишүүдийн эрх, үүрэг**

4.1. Үнэлгээний хороо, түүний гишүүд нь хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хуулийн 6 дугаар зүйлд заасан худалдан авах ажиллагааны зарчмаас гадна хараат бус байх зарчмыг баримтална.

4.2. Үнэлгээний хороо, түүний гишүүд нь тендер шалгаруулалтыг зохион байгуулах, тендер үнэлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан журам, аргачлалыг мөрдөх бөгөөд хуульд зааснаас бусад арга хэлбэрээр тендерт оролцогч болон түүний эрх, ашгийг төлөөлөн илэрхийлж буй аливаа этгээдтэй харилцаа тогтоохгүй байна.

4.3. Тендер шалгаруулалттай холбоотойгоор хөндлөнгөөс нөлөөлөх аливаа оролдлогын талаар үнэлгээний хорооны гишүүн нь хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.5 дахь заалт, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн дагуу арга хэмжээ авна.

4.4. Үнэлгээний хорооны гишүүд хуралдаанд шийдвэр гаргахад өөрийн саналыг хараат бусаар илээр өгч оролцох ба гишүүн тус бүр саналын нэг эрхтэй байна.

4.5. Үнэлгээний хорооны дарга нь хуралдааныг товлох, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах, үнэлгээний хорооны үйл ажиллагааг хуульд нийцүүлэн удирдан зохион байгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах үүргийг хүлээнэ.

4.6. Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь хуралдааны товыг гишүүдэд зарлан мэдэгдэх, зохион байгуулах, худалдан авах ажиллагаанд баримтлах хууль тогтоомжийн талаарх мэдээллээр гишүүдийг хангах, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөх, шийдвэрийг гишүүдээр баталгаажуулах ажлуудыг хариуцна. Хэрэв тендерт оролцогч холбогдох журмын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигтэй танилцах хүсэлт гаргавал нууц хадгалах баталгаа гаргуулснаар баримт бичигтэй танилцуулах зэрэг үүргийг хүлээнэ.

4.7. Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой баримт бичгийг тухай бүр худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан нийтлэх, баримт, материалыг хуулийн 49 дүгээр зүйлийн дагуу бүрдүүлж, хавтаст хэрэг болгон хадгалах үүргийг хүлээнэ.

4.8. Захиалагч үнэлгээний хорооны гишүүдэд дараах журмаар урамшуулал олгож болно:

4.8.1. хуулийн 47 дүгээр зүйлийн 47.4 дэх хэсгийн дагуу үнэлгээний хороонд ажилласан гишүүнд ажилласан цаг тутам үндэслэн ТҮ-7 нэгдүгээр шатлалын нэг цагийн цалинтай тэнцэх урамшуулал;

4.8.2. тендер шалгаруулалтын үйл ажиллагаатай холбогдуулан захиалагч байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу илүү цагаар ажиллуулах шийдвэр гарсан бол холбогдох хууль, журамд заасны дагуу илүү цагаар ажиллуулсан цалин хөлс.

4.9. Үнэлгээний хороо нь захиалагч болон эрх бүхий байгууллагаас дараах үндэслэлээр гаргасан шийдвэрийг хүлээн авч, зөрчлийг арилгана:

4.9.1. үнэлгээний хорооноос боловсруулсан тендерийн баримт бичиг, үнэлгээний дүгнэлтийг хянаж, баталгаажуулах;

4.9.2. хуульд зааснаар гомдол хянан шийдвэрлэх эрх бүхий байгууллага, шүүхээс гаргасан шийдвэр.

4.10. Үнэлгээний хороо нь тендер шалгаруулалтын явцад хууль тогтоомжид заасан зөрчил гарсан тохиолдолд тухайн нөхцөл байдлыг тогтоолгохоор худалдан авах ажиллагааны улсын байцаагч болон бусад байгууллагад шилжүүлэх тухай саналаа захиалагчид бичгээр гаргана.

#### **Тав. Тендерийн баримт бичиг боловсруулах, худалдах, тендер шалгаруулалтын урилгыг нийтлэх**

5.1. Үнэлгээний хороо бараа, ажил, үйлчилгээний онцлогоос хамааруулан төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жишиг баримт бичигт нийцүүлэн тендерийн баримт бичгийг боловсруулан тухайн салбарт аж ахуй эрхэлж буй иргэн, хуулийн этгээдээс хараат бусаар, зах зээлийн тооцоо судалгаанд үндэслэж, зөвхөн зайлшгүй шаардлагатай шалгуур үзүүлэлт, чадавхын шаардлагыг тогтоох зарчим баримтална.

5.2. Үнэлгээний хороо нь боловсруулсан тендерийн баримт бичиг болон түүний нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжид нийцүүлэн батлуулахаар захиалагчид хүргүүлнэ.

5.3. Захиалагчийн баталсан тендерийн баримт бичгийг худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан холбогдох журамд зааснаар сонирхогч этгээдэд саадгүй олгоно.

5.4. Зөвлөхөөс бусад үйлчилгээ, бараа, ажлын тендерийн урилгыг энэ журмын Хавсралт 2-т, зөвлөх үйлчилгээний дэлгэрэнгүй жагсаалтад орох санал ирүүлэхийг хүссэн урилгыг Хавсралт 3-т заасан маягтуудын дагуу боловсруулна.

5.5. Энэ журмын 5.3-т заасан зарлал, урилгыг хуулийн 21 дүгээр зүйлийн дагуу үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, худалдан авах ажиллагааны цахим систем болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр олон нийтэд зарлан мэдээлнэ.

5.6. Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтад заасан доод хязгаараас давсан төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээний тендерийн урилгыг цахим системд заавал нийтэлнэ.

5.7. Тендерийн урилгыг бэлтгэхдээ хууль болон “Босго үнэ батлах тухай” Засгийн газрын 2013 оны 68 дугаар тогтоол, Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-д заасны дагуу бэлтгэж, зарлан мэдээлнэ.

### **Зургаа. Үнэлгээний хорооны хуралдаан, үнэлгээний дүгнэлт**

6.1. Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанаас хамтын шийдвэр гаргана.

6.2. Үнэлгээний хорооны гишүүд нь товлогдсон хугацаанд хуралдаанд оролцох үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй нь холбогдох хууль тогтоомжид зааснаар хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

6.3. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд багтаан хурдан шуурхай зохион байгуулах бөгөөд энэ зорилгоор тендерийг хянан үзэх, үнэлэх эхний хуралдааныг тендер нээсэн өдөрт багтаан зохион байгуулж, зайлшгүй шаардлагатай бол тодорхой хугацаагаар хойшлуулж дараагийн хуралдааныг товлон.

6.4. Үнэлгээний хорооны хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа оролцоогүй, үнэлгээний хорооны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ зөрчсөн гишүүнийг үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлүүлэх, худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны гэрчилгээ хүчингүй болгуулах болон холбогдох бусад арга хэмжээ авах тухай саналаа үнэлгээний хорооноос захиалагч, Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон бусад байгууллагад хүргүүлж болно.

6.5. Үнэлгээний хорооны хуралдаан нь дарга, нарийн бичгийн даргыг оролцуулан нийт гишүүдийн 75 хувиас багагүй хувийн ирцтэйгээр хуралдсанаар хүчин төгөлдөрт тооцогдоно.

6.6. Хуулийн 47 дугаар зүйлийн 47.7 дахь хэсэгт зааснаар үнэлгээний хорооны шийдвэр нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд энэ журмын Хавсралт 2-т заасан маягтад нийцүүлэн боловсруулна.

6.7. Хуралдаанаар хэлэлцсэн тодорхой асуудлыг шийдвэрлэхдээ оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх боловч үнэлгээний дүгнэлтийг бүхэлд нь дэмжсэн шийдвэрийг үнэлгээний хороонд томилогдсон нийт гишүүдийн олонх дэмжсэнээр уг үнэлгээний дүгнэлт хүчин төгөлдөрт тооцогдоно.

6.8. Үнэлгээний хорооны гишүүд нь хуралдаанд оролцсон эсэхээс үл хамааран дүгнэлтийг бичгээр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор үнэлгээний дүгнэлтэд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд ийнхүү гарын үсэг зурахдаа

хуралдаанд оролцсон гишүүд нь үнэлгээний дүгнэлтийг дэмжсэн эсэхийг тусгайлан тэмдэглэнэ.

6.9. Үнэлгээний хорооны гишүүн үнэлгээний дүгнэлтээс эсрэг саналаа дүгнэлтэд тэмдэглэсэн эсхүл дүгнэлтэд хавсаргаж өгсөн бол захиалагч дүгнэлтийг хянан баталгаажуулахдаа тухайн саналыг нягталж шалгана.

6.10. Үнэлгээний хорооны гишүүн үнэлгээний дүгнэлтэд гарын үсэг зурахаас үндэслэлгүйгээр татгалзсан нь дүгнэлтийн хүчинтэй байдалд нөлөөлөхгүй боловч түүнийг үнэлгээний хорооны гишүүний үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйд тооцох үндэслэл болно.

6.11. Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нь “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын 2.2-д зааснаар хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасан баримт бичгийг худалдан авах ажиллагааны цахим системийн холбогдох хэсэгт тухай бүр байршуулж, тус журмын 2.5-д зааснаар шалгарсан тендерт оролцогчийн тендерийн ил болгох материалыг худалдан авах ажиллагааны цахим системд гэрээ байгуулах эрх олгосон өдөрт багтаан байршуулна.

### **Долоо. Захиалагч үнэлгээний дүгнэлтийг хүлээн авах, түүнээс татгалзах**

7.1. Үнэлгээний хороо нь үнэлгээний дүгнэлтийг дараах баримт бичгийн хамт захиалагчид хүргүүлнэ:

7.1.1. үнэлгээний дүгнэлтээр гэрээ байгуулах эрх олгох бол Хавсралт 4-ийн дагуу боловсруулсан гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж;

7.1.2. холбогдох үнэлгээний аргачлал, зааврын дагуу үйлдсэн баримт бичиг, үнэлгээний тайлан.

7.2. Энэ журмын 6.1-д заасан дүгнэлтийг хүлээн авсан захиалагч нь үндэслэлгүйгээр дүгнэлтээс зөрүүтэй шийдвэр гаргахгүй.

7.3. Захиалагч үнэлгээний хорооны шийдвэр, үйл ажиллагаа илтэд хууль зөрчсөн болохыг олж тогтоосон бол дүгнэлтийг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор зөрчлийг арилгах тухай шаардлагыг үнэлгээний хороонд бичгээр мэдэгдэнэ. Энэхүү мэдэгдэлд зөрчлийн үндэслэл, тайлбарыг заавал дурдсан байна.

7.4. Үнэлгээний хороо нь захиалагчийн мэдэгдлийг хүлээн авсан даруй буюу ажлын 3 хоногт багтаан хуралдаж дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж, захиалагчид хүргүүлнэ. Үүнд:

7.4.1. Захиалагчаас ирүүлсэн шаардлага үндэслэлтэй бол түүнийг хууль тогтоомжид нийцүүлэн залруулж, захиалагчийн шийдвэрийг үндэслэн дахин дүгнэлт гаргах;

7.4.2. Захиалагчаас ирүүлсэн шаардлага үндэслэлгүй бол өмнө гаргасан дүгнэлтийн үндэслэлийг тодорхой нотолж, өмнөх шийдвэрийг захиалагчид дахин хүргүүлэх.

7.5. Захиалагч үнэлгээний дүгнэлтийг хүлээн авч гэрээ байгуулах эрх олгох, тендерээс татгалзах шийдвэрийг гаргасан бол үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга шийдвэрийг тендерт оролцогчдод хүргүүлэх, худалдан авах ажиллагааны цахим системд байршуулах ажлыг хариуцан зохион байгуулна.

7.6. Захиалагчид хүргүүлэх гэрээ байгуулах эрх олгох тухай зөвлөмжийг Хавсралт 4-т нийцүүлэн боловсруулна.

### **Найм. Хариуцлага**

8.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Үнэлгээний хорооны гишүүн хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдсон бол захиалагч түүнийг үнэлгээний хорооны гишүүний үүргээс чөлөөлж, хариуцлага хүлээлгэхээр холбогдох байгууллагад санал гаргана. Мэдээллийн сангаас нэрийг нь хасуулахаар санал хүргүүлнэ.

-ооо-

## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮНЭЭР АЖИЛЛАХЫГ ЗӨВШӨӨРСӨН МЭДҮҮЛЭГ

.....-ын үнэлгээний хорооны гишүүнээр  
томилогдсон .....овогтой..... би

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах дараах шаардлагыг хангасан бөгөөд сүүлийн 1 жилийн хугацаанд тус хуулийн 50.1-д заасан үүргээ зөрчөөгүй;
- “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг тухай бүр үнэн зөвөөр гаргаж захиалагчид хүргүүлэх;
- Үнэлгээний хорооны гишүүний хувиар хууль тогтоомжид заасан бүх эрх, үүргээ түргэн шуурхай, шударгаар биелүүлэх болохоо мэдэгдэж байна.

Гарын үсэг: .....

Огноо: .....

	Овог, нэр	Албан тушаал	Гарын үсэг	Огноо	Цаг, минут
Хүлээн авсан					



## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо<sup>1</sup> : \_\_\_\_\_  
Тендер шалгаруулалтын нэр: \_\_\_\_\_  
Тендер шалгаруулалтын дугаар: \_\_\_\_\_

**[Захиалагчийн нэр]** эрх бүхий тендерт оролцогчдоос **[барааны товч тодорхойлолт]**-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдлээр нь **[дүн]**<sup>2</sup> төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[30]** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ:

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:

Тендерийн хамт **[дүн]**<sup>3</sup> төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа<sup>4</sup> ирүүлнэ.

Тендерийг **[тендер хүлээн авах эцсийн огноо, цаг]**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **[огноо]-ны өдрийн, [цаг]**<sup>5</sup>-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх:<sup>6</sup>

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[Урьдчилсан худалдан авах ажиллагааны зарлал]

**[Захиалагчийн тодорхой хаяг**

**(өрөөний дугаар, харилцах албан тушаалтны нэр, утас/факс)]**

<sup>1</sup> Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.

<sup>2</sup> Тендерийн баримт бичгийг түүнийг бэлтгэхэд буюу хувилж олшруулах, шуудангаар хүргэх зэрэгт зарцуулсан өртгөөр үнэлж, тендер шалгаруулалтад оролцохыг хүсэгчдэд энэ үнээр саадгүй олгоно.

<sup>3</sup> Төсөвт өртгийн 1-2 хувьтай тэнцүү байна.

<sup>4</sup> Барааны төсөвт өртөг 50 сая төгрөгөөс дээш бол, тендерийн баталгаа ирүүлэхийг заавал шаардана.

<sup>5</sup> Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

<sup>6</sup> Гадаадын этгээдийг худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй бол “Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй” гэж бичнэ.

## ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

1. *[Захиалагч байгууллагын нэр]* нь *[төслийн/үйлчилгээний нэр]*-ийг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь *[товч танилцуулга, байгууллага, хэрэгжүүлэх хугацаа гэх мэт]* болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг (нийтлэл, ижил төрлийн ажлын туршлага, ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл гэх мэт) ирүүлнэ. Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг *[огноо]*-ний *[цагийн]* хооронд авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар *[мэдүүлэг хүлээн авах эцсийн огноо]*-ний дотор ирүүлнэ үү.

*[Захиалагчийн тодорхой хаяг  
(өрөөний дугаар, харилцах албан тушаалтны нэр, утас/факс)]*

“Үнэлгээний хорооны зохион байгуулалт,  
үйл ажиллагаа, урамшууллын  
журам”-ын 4 дүгээр хавсралт

Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийн загвар

[Төрийн худалдан авах ажиллагааны газрын загварыг хэрэглэх]

ТӨСӨД

“Үнэлгээний хорооны зохион байгуулалт,  
үйл ажиллагаа, урамшууллын  
журам”-ын 4 дүгээр хавсралт

**ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ САНАЛ**

1	Хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн тендерт оролцогч (гэрээ байгуулах эрх олгохоох санал болгож буй).		
	1.1. Нэр		
	1.2. Хаяг		
2	Хэрэв тендер нь итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжсан бол жинхэнэ гүйцэтгэгчийн:		
	2.1 Нэр		
	2.2 Хаяг		
3	Түншлэл бол, гишүүн бүрийн нэр, улс, болон гэрээний гүйцэтгэлийг хариуцах хувийг жагсаах.	1	
		2	
		3 ... гэх мэт	
4	Бараа/материалын гарал үүслийн улс		
5	Гэрээнд гарын үсэг зурахаар тооцоолсон огноо (он, сар)		
6	Бараа, ажил (хүргэж суурилуулах буюу гүйцэтгэх) дуусгах тооцоолсон хугацаа		
7	Тендерийн зарлагдсан үнэ (тендерийг нээхэд зарлагдсан) <sup>1</sup>	Дүн	Хувь
8	Алдааг залруулсан <sup>2</sup>		
9	Үнийн хөнгөлөлт <sup>3</sup>		
10	Бусад тохируулга <sup>4</sup>		
11	Гэрээний санал болгосон үнэ <sup>5</sup>		

